

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2023 оны __ дугаар
сарын __-ны өдөр

№

Улаанбаатар хот

Гэрээг нэг талаас “Биеийн тамир, спортын улсын хороо”-г төлөөлж
..... (цаашид “Түрээслүүлэгч” гэх), нөгөө талаас
..... (цаашид “Түрээслэгч” гэх) нар (хамтад нь “Талууд”
гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 318-326 дугаар зүйл болон холбогдох бусад хууль,
журмыг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцон байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1 Энэхүү Гэрээгээр Түрээслүүлэгч нь Сүхбаатар дүүргийн 8-р хороонд байрлах Спортын төв ордны А заалыг /цаашид Хөрөнгө гэх/ Түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх, нөгөө талаас Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг төлөх, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

2. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү Гэрээ нь 2023 оныцаг хүртэл байна.

2.2 Түрээсийн төлбөр

2.2.1 Зааланд зохион байгуулагдах..... явагдах бөгөөд зайлшгүй гэрээ байгуулна.

2.2.2 хөнгөлөлттэй/хөнгөлөлтгүй үнээр нийт төгрөг байна.

2.2.3 Төлбөрийг Биеийн тамир, спортын улсын хорооны /РД-9111891/ Төрийн сан банк дахь 100900008433 тоот дансанд тэмцээн эхлэхээс хоногийн өмнө хийнэ.

3. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

3.1.1 Түрээслүүлэгч нь ашиглалтын шаардлага хангасан, биет байдлын болон эрхийн зөрчилгүй хөрөнгийг Түрээслэгчийн эзэмшил ашиглалтанд шилжүүлэх үүрэгтэй.

3.1.2 Түрээслүүлэгч нь хөрөнгийн түрээсийн төлбөрийг Түрээслэгчээс шаардах эрхтэй.

3.1.3 Түрээслэгч Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

3.1.4 Заал танхимын цэвэрлэгээ, үйлчилгээний явц, гүйцэтгэлтэй танилцаж холбогдох санал, гомдлыг гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй

3.1.5 Заал түрээслэх хугацааг хойшлуулах болон цуцлах тохиолдолд ажлын 3 хоногийн өмнө Түрээслүүлэгчид урьдчилан мэдэгдэнэ.

3.1.6 Түрээслэгч талын хүсэлтийг бичгээр болон амаар хүлээн авч, заал ашиглалтын төлөвлөгөөнд тусгах,

- 3.1.7 СТО-ны зохион байгуулагч нь заалны түрээсийн төлбөрийг тушаасан санхүүгийн баримтыг үндэслэн холбогдох ажлыг зохион байгуулах
- 3.1.8 Түрээслэгч талд шаардлагатай эд зүйлс, заал танхимыг тэмцээн эхлэхээс 30-60 минутын өмнө бэлэн болгох
- 3.1.9 Заал танхимыг ашиглаж эхлэх, хүлээлгэн өгөх болон бусад заал ашиглалттай холбоотой асуудлаар түрээслэгч талд шаардлага тавих
- 3.1.10 Шаардлагатай тохиолдолд түрээслэгч талаас хохирлыг нэхэмжлэн барагдуулах
- 3.1.11 Түрээслэгчээс шалтгаалаагүй осол гэмтэл гарсан нөхцөлд түүнийг арилгах шаардлагатай арга хэмжээ авах
- 3.1.12 Хэрвээ гэрээнд тусгагдсан өдрүүдэд БТСУХ-аас олон улсын болон улсын чанартай тэмцээн, уралдаан А зааланд зохион байгуулах бол түрээслэгч байгууллагад ажлын 3 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

4. Түрээслэгчийн эрх, үүрэг

- 4.1.1 Хөрөнгийг Гэрээнд заасан нөхцөл болон зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй.
- 4.1.2 Гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 4.1.3 Гэрээ дуусгавар болоход хөрөнгийн хэвийн элэгдэл хорогдолыг тооцон, бүрэн бүтэн байдлаар буцаан хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.1.4 Түрээслэгч Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүй хөрөнгийг бусдад давхар түрээслэх, худалдаалахыг хориглоно.
- 4.1.5 Тухайн арга хэмжээ гэрээнд заасан цагаас хойш сунгагдсан тохиолдолд цагийн төгрөгөөр тооцон түрээсийн төлбөр дээр нэмж түрээслүүлэгчийн эд хөрөнгө хариуцагчид төлнө.
- 4.1.6 Тэмцээний удирдамж, шүүгчийн бүрэлдэхүүн, спортын хэрэгсэл, материал хангамжтай холбогдсон асуудлыг өөрсдөө шийдвэрлэх бөгөөд гадна талбай болон заал танхимд тавигдах реклам сурталчилгааны материалыг түрээслэгч талтай тохиролцсоны үндсэн дээр заалны зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.
- 4.1.7 Ордны дотоод журам, заал түрээслэх журмыг чанд мөрдөх ба спортын төв ордон дотор тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, ашиглалтын цаг хугацаа, дэг журам, харуул хамгаалттай холбогдсон асуудлыг бүрэн хариуцах ба эд хөрөнгийн эвдрэл гэмтэл, хохирлыг төлж барагдуулах.
- 4.1.8 Заал танхимын цэвэрлэгээ, үйлчилгээний явц, гүйцэтгэлтэй танилцаж холбогдох санал, гомдлыг гаргаж шийдвэрлүүлэх.
- 4.1.9 Заал түрээслэх хугацааг хойшлуулах болон цуцлах тохиолдолд ажлын 3 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх.

5. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алданги төлнө.
- 5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай тал нь нөгөө талд төлөх үүрэгтэй.

6. Гэрээ цуцлах

- 6.1 Гэрээний аль нэг тал Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээг нэг талын санаачилгаар цуцална.
- 6.2 Гэрээг цуцалсан тохиолдолд гэм буруутай тал бусдад учирсан хохирол болон нөгөө талд учирсан хохирлыг өөрийн зардлаар арилгана.
- 6.3 Талууд Гэрээг цуцалсан тохиолдолд Түрээслэгч хөрөнгийг бүрэн бүтэн, эвдрэл, гэмтэлгүй Түрээслүүлэгчийн өмчлөлд 7 хоногийн дотор шилжүүлэх өгнө.

7. Бусад

- 7.1 Талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 7.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж Талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8. Талууд

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ:

ТҮРЭЭСЛЭГЧ: